



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2024/11/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113

Цахим хаяг: Ikhubayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөгөөр/	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /мянган төгрөгөөр/.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөгөөр/.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1.1 Зөвлөмж.....	8
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Т.АРИУНАА
ТАНАА

2024-03-25 № 119
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 447.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 30.3 сая төгрөгийн хөрөнгө акталж, бүтцийн өөрчлөлтөөр 84.1 сая төгрөгийн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлсэн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь Завсрын аудитаар өгсөн хөрөнгийн тооллогыг чанартай хийж тооцоог бодож, баталгаажуулах, бараа материалын хөдөлгөөнийг агуулахын бүртгэлээр хөтөлж, тооцоо бодон, баталгаажуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, жилийн эцсийн аудитаар санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн дүн 56.4 сая төгрөгөөр, бараа материалын дүн 4.9 сая төгрөгөөр тооллогын бүртгэл зөрүүтэй, тооцоог бодож, баталгаажуулаагүй, мөн 2023 онд байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа 3 авто

машинд зарцуулсан шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог бодож баталгаажуулаагүй, сумын 2023 оны татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 4.1 хувиар буюу 15.3 сая төгрөгөөр, орлогын төрлөөрөө 6 нэр төрлийн орлого 37.7 сая төгрөгөөр тасарсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил нь тайлант үеийн өндөр үнэлэгдсэн эрсдэлтэй асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 зорилт, 32 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 83.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	716,716.6	747,315.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	522,622.9	516,709.4
33	АВЛАГА	112,974.6	146,298.1
35	БАРАА МАТЕРИАЛ	81,119.1	84,308.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,260,385.6	1,609,157.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,260,385.6	1,609,157.4
39200	Биет хөрөнгө	1,238,102.1	1,580,965.8
39300	Биет бус хөрөнгө	22,283.5	28,191.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,977,102.2	2,356,473.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,300.0	25,431.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,300.0	25,431.9
41300	Өглөг	20,300.0	25,431.9
41400	Урьдчилж орсон орлого	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,956,802.2	2,331,041.2
51	Засгийн газрын хувь оролцоо	1,956,802.2	2,331,041.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	465,524.7	465,524.7
51200	Хуримтлагдсан үр дүн	1,275,743.6	1,614,085.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	215,533.9	251,430.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,977,102.2	2,356,473.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,094,334.0	1,543,347.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	373,078.2	314,136.5
110	Орлогын албан татвар	170,243.7	183,591.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	170,243.7	183,591.2
113	Хөрөнгийн албан татвар	92,643.5	82,089.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	110,190.9	48,455.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	113,320.6	497,137.2
120	Нийтлэг татварын бус орлого	113,320.6	496,817.2
121	Хөрөнгийн орлого	0.0	320.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	607,935.2	732,073.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	770,694.3	920,752.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	770,694.3	920,752.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,889.3	621,007.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,602.0	282,750.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,875.7	33,882.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,097.1	31,096.2
2104	Хангамж, бараа материалын зардал	25,786.2	49,060.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,477.8	17,035.0
2107	Томилолт, зочны зардал	9,124.0	19,668.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,532.8	8,625.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,393.7	178,889.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	319,805.0	299,745.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	323,639.7	622,594.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,578,419.6	284,196.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,254,779.9	338,398.7

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,291,426.8	4,291,426.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-79,844.7	-79,844.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,211,582.1	4,211,582.1
9	Тайлант үеийн үр дүн	-2,254,779.9	-2,254,779.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,956,802.2	1,956,802.2
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,956,802.2	1,956,802.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-56.7	-56.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,956,745.5	1,956,745.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	35,896.9	35,896.9
19	Тайлант үеийн үр дүн	338,398.7	338,398.7
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	2,331,041.2	2,331,041.2

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,063,809.7	1,151,307.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	373,078.2	314,136.5
110	Орлогын албан татвар	170,243.7	183,591.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	170,243.7	183,591.2
113	Хөрөнгийн албан татвар	92,643.5	82,089.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	110,190.9	48,455.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,279.3	3,828.6
1181	Газрын төлбөр	45,183.6	44,627.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	61,728.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,138.1	112,573.9
120	Нийтлэг татварын бус орлого	86,138.1	112,253.9
121	Хөрөнгийн орлого	0.0	320.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	604,593.4	724,597.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	688,608.8	801,839.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	688,608.8	801,839.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	602,880.4	762,116.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,434.7	283,113.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,705.1	34,454.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,110.8	29,464.2
2104	Хангамж, бараа материалын зардал	29,230.5	35,038.2
2105	Нормативт зардал	0.0	308.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,222.8	18,924.4
2107	Томилолт, зочны зардал	9,124.0	19,668.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,662.8	261,471.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,389.7	79,674.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,728.5	39,722.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	375,200.8	349,468.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	231,620.9	315,382.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	231,620.9	315,382.0
2200	Дотоод эх үүсвэрээр	231,620.9	315,382.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-231,620.9	-315,382.0

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-40,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	40,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	143,579.9	-5,913.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	379,043.0	522,622.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	522,622.9	516,709.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,589,669.3	1,115,584.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	947,751.2	790,442.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	929,131.2	772,917.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	313,053.4	283,113.8
210101	Үндсэн цалин	232,677.1	216,941.2
210102	Нэмэгдэл	64,731.3	46,501.7
210104	Урамшуулал	15,645.0	19,670.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,301.1	34,454.6
210201	Тэтгэврийн даатгал	28,488.7	24,675.6
210202	Тэтгэмжийн даатгал	3,348.0	2,898.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,642.5	2,270.3
210204	Ажилгүйдлийн даатгал	565.7	405.6
210205	Эрүүл мэндийн даатгал	6,256.2	4,204.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	275,909.3	268,554.6
210301	Гэрэл, цахилгаан	25,059.7	19,527.0
210302	Түлш, халаалт	246,249.6	245,684.1
210303	Цэвэр, бохир ус	4,600.0	3,343.6
2104	Хангамж, бараа материалын зардал	42,269.9	33,817.0
210401	Бичиг хэрэг	3,750.0	3,681.4
210402	Тээвэр, шатахуун	22,522.9	22,498.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,580.0	2,314.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,900.0	3,829.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,517.0	1,493.8
2105	Нормативт зардал	650.0	308.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	650.0	308.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,880.0	52,451.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,130.0	22,240.0
210604	Урсгал засвар	30,750.0	30,211.3
2107	Томилолт, зочны зардал	22,850.0	18,588.0
210702	Дотоод албан томилолт	22,850.0	18,588.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,303.0	4,503.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,766.0	3,658.3
210803	Даатгалын үйлчилгээ	684.0	104.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	373.0	260.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	148.0	77.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	960.0	178.0
210807	Газрын төлбөр	372.0	226.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,914.5	77,127.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,914.5	74,130.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000.0	2,996.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,620.0	17,524.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,620.0	17,524.8

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	9,300.0	9,300.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,750.0	6,317.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,570.0	1,907.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	413,725.4	285,142.0
223001	Бусад хөрөнгө	413,725.4	285,142.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	228,192.7	40,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	228,192.7	40,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,589,669.3	1,092,037.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	219,647.6	219,647.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	-
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	219,647.6	219,647.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	968,266.7	821,079.3
320001	Орон нутгийн төсвөөс	968,266.7	821,079.3
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	401,755.0	51,310.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000.0	17,283.6
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,000.0	34,027.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	327,755.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	327,755.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	304,208.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,179.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,179.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,605.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,069.08
210301	Гэрэл, цахилгаан	1,069.08
2104	Хангамж, бараа материалын зардал	1,221.17
210402	Тээвэр, шатахуун	906.17
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	315.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100.00
210604	Урсгал засвар	1,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,080.00
210702	Дотоод албан томилолт	1,080.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,421.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,421.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	714.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	714.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,573.78
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,573.78
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	13,573.78
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,179.34
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,179.34
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,185.71
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,993.63

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитаар нийт 37,687.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлжээ.

3.1.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

1. Татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2023 оны татварын орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр 4.1 хувиар буюу 15,324.6 мянган төгрөгөөр, 7 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 37,687.4 мянган төгрөгөөр дутуу биелүүлж, татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийн хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.19. -д /нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;/, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.-т /санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;/, 41 дүгээр зүйлийн 41.2.-т /Бүх шатны төсөв захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ/, 41.2.1.-т /Хуулийн дагуу, улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.30.-д /"татварын улсын байцаагч" гэж энэ хуулийн дагуу татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар төлөгчид үйлчлэх, татвар хураах, тайлан хүлээн авах, хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий татварын албанд ажилладаг, эрх олгогдсон төрийн захиргааны албан хаагчийг;/ заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

- Татварын болон татварын бус орлогыг төлөвлөхдөө тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, орлогын нэр төрлийг бүрэн төвлөрүүлэх.
- Сумын татварын алба буюу татварын байцаагч, татварын орлого бүрдүүлэлтэд хамаарах алба хаагч нарыг удирдлагаар хангаж, ажлын хариуцлагыг нь сайжруулж нэмэгдүүлж хууль тогтоомжид заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2024 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудита	д	
		Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлагдтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1				1		
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 497,981.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 30,466.7 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 6,851.1 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 460,663.3 мянган төгрөгийн 18 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 6.1 хувийг залруулагдаагүй, 93.9 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн үндэслэл

Тайлбар: Төсөвт байгууллага, тусгай зориулалтын сангуудын 2023 санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар ЗДТГ, ХХС-д хүргүүлсэн **5,978.5** мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, албан шаардлага, ОНХС, БХС, МХС-д хүргүүлсэн **427,172.4** мянган төгрөгийн 8 албан шаардлага буюу нийт **433,150.9** мянган төгрөгийн зөрчил бүрэн хэрэгжиж, ЗДТГ-т хүргүүлсэн **29,280.0** мянган төгрөгийн 4 албан шаардлага, Засаг даргад хүргүүлсэн **37,687.4** мянган төгрөгийн 1 албан шаардлага буюу нийт **66,967.4** мянган төгрөгийн зөрчлийг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хамруулан авч үзлээ. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх **5,083.5** мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшинээс **8,727.8** мянган төгрөгөөр буюу **2.7** дахин бага байна.

Иймд Говь-Угтаал сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говь-Угтаал сумын ЗДТГ	3	3,632.4	2	2,566.90	3	3,632.40	3	3,632.40				
Говь-Угтаал сумын ОНХС	1	7,317.5			1	7317.5	1	7317.5				
Говь-Угтаал сумын МХС	1	19,516.7	1	19,516.7			1	19,516.7				
Дүн	5	30,466.6	3	22,083.6	4	10,949.9	5	30,466.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говь-Угтаал сумын ИТХ	2	510.0	1	510.00	1							
Говь-Угтаал сумын ЗДТГ	6	5,712.4	1	1,501.5	5	4,210.90						
Говь-Угтаал сумын СХС	2	4,839.7	2	4,839.7								
Говь-Угтаал сумын ОНХС	1	120,332.6			1	120,332.6						
Говь-Угтаал сумын БХС	1	28,300.0			1	28,300.0						
Говь-Угтаал сумын МХС	2	7,869.0			2	7,869.0						
Дүн	14	167,563.7	4	6,851.20	10	160,712.5	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
Говь-Угтаал сумын ЗДТГ	1	-	-	-					1				
Дүн	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
Говь-Угтаал сумын ЗДТГ	3	29,280.0			2	29,280.0	-	-	1				
Говь-Угтаал сумын ОНХС	4	270,670.8			4	270,670.8							
Говь-Угтаал сумын ОННТ	1	37,687.5					1	37,687.5					
Дүн	8	337,638.3	-	-	6	299,950.8	1	37,687.5	1	-	-	-	-
Нийт дүн	9	337,638.3	-	-	6	299,950.8	1	37,687.5	2	-	-	-	-